

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ (2011 ОНЫ ЭХНИЙ 11 САРЫН БАЙДЛААР)


I. ТӨСӨВ:

Төсвийн орлого

Аймгийн төсөвт эхний 11 сард 7180.3 сая төгрөгийн орлого төвлөрсөн нь өмнөх оны мөн үеийнхээс 1282.3 сая төгрөг буюу 21.7 хувиар өсчээ.

Өмнөх оны мөн үеийнхээс татварын орлого 305.6 сая буюу 9.8 хувиар, татварын бус орлого 11.9 сая буюу 4.9 хувиар, хөрөнгийн орлого 53.8 сая буюу 2.1 дахин өсчээ.


Төсвийн орлогын 47.5 хувийг татварын орлого, 3.6 хувийг татварын бус орлого, 1.4 хувийг хөрөнгийн орлого, 47.5 хувийг улсаас олгож буй санхүүгийн дэмжлэг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс хөрөнгийн орлогын эзлэх хувь 0.6 пунктээр өсч татварын бус орлогынх 0.5 пунктээр, татварын орлогынх 5.1 пунктээр буурсан байна.



Төсвийн зарлага

Аймгийн нэгдсэн төсвийн зарлага эхний 11 сард 33544.8 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 5484.2 сая төгрөг буюу 19.5 хувиар өссөн байна. Төсвийн зарлага өмнөх оны мөн үеийнхээс 5484.2 сая төгрөг буюу 19.5 хувиар өсөхөд цалин хөлс 3559.0 сая төгрөг буюу 22.3 хувиар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 213.1 сая төгрөг буюу 13.1 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 2595.9 сая төгрөг буюу 31.9 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Төсвийн зарлагын 58.1 хувийг цалин хөлс, 5.5 хувийг НДШ, 32.0 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 3.9 хувийг татаас ба шилжүүлгийн зардал тус тус бүрдүүлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс цалин хөлсний эзлэх хувь 1.3 пунктээр, бараа үйлчилгээний бусад зардалын эзлэх хувь 3.0 пунктээр өсч, татаас ба шилжүүлгийнх 0.6 пунктээр буурсан байна.



Өглөг,авлага

Төсөвт газруудын өглөг 638.5 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 62.5 сая төгрөг буюу 10.8 хувиар өссөн байна. Өглөгийн 9.8 хувийг түлш халаалтын зардал, 13.3 хувийг тээврийн зардал, 5.5 хувийг цалин, 1.9 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 39.4 хувийг эмийн зардал, 10.5 хувийг хоолны зардал, 3.8 хувийг гэрэл цахилгааны зардал, 15.7 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.Өглөг өмнөх оны мөн үеийнхээс 10.8 хувиар өсөхөд эмийн өглөг 2.1 дахин, хоолных 48.4 хувиар, тээвэрийнх 10.4 хувиар, гэрэл цахилгааных 2.0 дахин өссөн нь нөлөөлжээ. Өмнөх оны мөн үеийнхээс эмийн эзлэх хувь 19.1 пунктээр, гэрэл цахилгааных 1.7 пунктээр, хоолных 2.7 пунктээр өсч, түлш халаалтынх 11.3 пунктээр, цалингийнх 3.0 пунктээр, тээвэрийнх 0.1 пунктээр, тус тус буурсан байна.

II. АРИЛЖААНЫ БАНК.

Арилжааны банкуудын аж ахуй нэгж байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл эхний 11 сард 62465.9 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 29224.5 сая төгрөг буюу 87.9 хувиар өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.3 хувийг эзэлж байгаа нь өмнөх сарынхаас 0.8 пункт, өмнөх оны мөн үеийнхээс 0.5 пунктээр буурсан байна. Эхний 11 сард олгосон зээлийн өрийн үлдэгдлийн 58.8 хувь нь ХААН банк, 24.5 хувь нь Хадгаламж банк, 15.0 хувь нь Хас банк, 1.7 хувь нь Төрийн банкинд ногдож байна. Байгууллага, иргэдийн хугацаатай ба хугацаагүй хадгаламж 29988.1 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 10231.9 сая төгрөг буюу 51.8 хувиар өссөн байна. Эхний 11 сард 45458 хүнд 56050.4 сая төгрөгийн зээл олгож, байгууллага, иргэдээс 45959.7 сая төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн байна.

III. НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ:

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 18478.1 сая төгрөг, зарлага 17273.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 3729.7 сая төгрөг буюу 25.3 хувиар, зарлага 2357.7 сая төгрөг буюу 15.8 хувиар нэмэгдлээ.Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеийнхээс нэмэгдэхэд нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 1621.7 сая төгрөг буюу 29.1 хувиар өссөн нь нөлөөлсөн байна. Нийгмийн даатгалын сангийн зарлага нэмэгдэхэд тэтгэвэр 2593.9 сая төгрөг буюу 20.8 хувиар, тэтгэмж 49.6 сая төгрөг буюу 9.9 хувиар, өссөн нь нөлөөлсөн байна. Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 15055.2 сая төгрөг болсны 80.2 хувийг өндөр настны, 13.1 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 6.7 хувийг тэжээгчээ алдсаны тэтгэвэр эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад өндөр настны тэтгэвэр 2.0 пунктээр өсч, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр 1.3 пунктээр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 0.6 пунктээр буурсан байна.

Нийгмийн халамж:


Эхний 11 сард нийгмийн халамжийн сангаас 144174 хүнд 32911.8 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо 7325 хүнээр буюу 5.3 хувиар, олгосон тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ 20731.9 сая төгрөг буюу 2.7 дахин өссөн байна.Нийгмийн

халамжийн тэтгэвэр тэтгэмж авагчдын 2.8 хувь нь жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, 1.7 хувь нь халамжийн тэтгэвэр авагчид, 0.7 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэд, 0.8 хувь нь ахмад настанг асарч буй иргэд, 6.9 хувь нь алдарт эхийн одонтой эхчүүд, 79.5 хувь нь хүний хөгжил сангийн хишиг хувь авагчид байна. Нийгмийн халамжийн сангаас 32911.8 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж олгосоны 1341.6 сая төгрөг буюу 4.1 хувийг халамжийн тэтгэвэрт, 733.1 сая төгрөг буюу 2.2 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд, 1391.3 сая төгрөг буюу 4.2 хувийг алдарт эхийн одонтой эхчүүдэд, 346.4 сая төгрөг буюу 1.0 хувийг ахмад настанг асарч буй иргэдэд, 278.7 сая төгрөг буюу 0.8 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэдэд, 85.1 хувийг хүний хөгжил сангийн хишиг хувь авагчдад зарцуулсан байна.

IV. ХӨДӨӨ АЖ АХУЙ:

Аймгийн хэмжээгээр 2011 оны эхэнд төллөх насны нийт 933.3 мянган эх мал тоологдсон. 2011 оны эхний 11 сарын байдлаар 818.8 мянган мал буюу оны эхэнд тоологдсон нийт эх малын 87.7 хувь нь төллөсөн байна. Ингэний 56.9 хувь, гүүний 76.7 хувь, үнээний 78.1 хувь, эм хонины 88.2 хувь, эм ямааны 89.2 хувь нь төллөжээ.


**Мал төллөлтийн хувь,
2011 оны эхний 11 сарын байдлаар**



Гарсан төлийн 96.8 хувь буюу 794.2 мянган төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийн төл бойжилтын хувиас 43.8 функтээр их байна. Хурга 97.1 хувь, ишиг 97.3 хувь байгаа ба өмнөх оны мөн үеийнхээс төл бойжилтын хувь малын 5 төрөл тус бүр дээр өндөр байна.


Төл бойжилтын хувь, 2011 оны эхний 11 сарын

байдлаар




Аймгийн хэмжээгээр 2011 оны эхний 11 сарын байдлаар 11 тэмээ, 786 адуу, 847 үхэр, 9.5 мянган хонь, 9.7 мянган ямаа буюу оны эхэнд тоологдсон нийт малын 1.0 хувьтай тэнцэх 20.8 мянган том мал зүй бусаар хорогдоод байна.

Зүй бусаар хорогдсон том мал, 2011 оны эхний 11 сарын байдлаар



Нийт хорогдсон малын 0.05 хувийг тэмээ, 3.8 хувийг адуу, 4.1 хувийг үхэр, 45.4 хувийг хонь, 46.6 хувийг ямаа эзэлж байна.


Зүй бусаар хорогдсон том малын бүтэц, төрлөөр



2011 оны эхний 11 сарын байдлаар Баян-Өндөр суманд 453 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.3 хувь, Бүрд суманд 5.2 мянган толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 2.8 хувь, Баруунбаян-улаан суманд 441 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.4 хувь, Баянгол суманд 129 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.1 хувь, Гучин-Ус суманд 923 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 1.1 хувь, Есөнзүйл суманд 1010 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 1.1 хувь, Өлзийт суманд 1064 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 1.2 хувь, Зүүнбаян-Улаан суманд 381 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.6 хувь, Богд суманд 429 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.2 хувь, Нарийн тээл суманд 2255 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 1.5 хувь, Сант суманд 13 толгой мал, Тарагт суманд 769 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 1.4 хувь, Төгрөг суманд 16 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.04 хувь, Уянга суманд 1844 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 1.5 хувь, Хайрхандулаан суманд 914 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын

0.7 хувь, Хужирт суманд 890 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.9 хувь, Хархорин суманд 3.7 мянган толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 2.4 хувь, Арвайхээр суманд 403 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.8 хувь тус тус хорогдсон байна. Бат-Өлзий суманд том малын хорогдол гараагүй байна.


Зүй бусаар хорогдсон малын тоо, сумаар



Аймгийн хэмжээнд 2011 оны эхний 11 сард 472 толгой мал өвчнөөр хорогдсон нь Баруунбаян-Улаан суманд 1 тэмээ, Баянгол суманд 1 адуу, 16 хонь, 8 ямаа, Гучин-Ус суманд 2 хонь, Өлзийт суманд 1 адуу, 35 хонь, 41 ямаа, Зүүнбаян-Улаан суманд 3 адуу, 5 үхэр, 14 хонь, 12 ямаа, Богд суманд 5 хонь, 11 ямаа, Нарийнтээл суманд 5 хонь, 8 ямаа, Сант суманд 6 хонь, 7 ямаа, Тарагт суманд 35 хонь, Хайрхандулаан суманд 1 адуу, 2 хонь, Хужирт суманд 19 адуу, 14 үхэр, 105 хонь, 110 ямаа, Арвайхээр суманд 2 хонь, 3 ямаа тус тус өвчнөөр хорогдсон байна.


Хээлтэгчийн хорогдол эхний 11 сарын байдлаар 4342 толгой байгаа ба оны эхний хээлтэгчийн 20.8 хувь нь хорогдоод байна. Нийт хорогдсон хээлтэгч малын 0.1 хувийг ингэ, 4.7 хувийг гүү, 5.4 хувийг үнээ, 43.3 хувийг эм хонь, 46.4 хувийг эм ямаа эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2100.0 га-д үр тариа, 312.0 га-д төмс, 147.26 га-д хүнсний ногоо тариалсан нь өмнөх онтой харьцуулахад үр тариа 383.3 га буюу 22.3 хувиар, төмс 30.8 га буюу 9.9 хувиар, хүнсний ногоо 5.06 га буюу 3.4 хувиар тус тус илүү тариалсан ба 2011 оны ургац хураалтын эцсийн мэдээгээр аймгийн хэмжээнд үр тариа хураалт 1620 га-аас 2057 тн, төмс 294.5 га-аас 3068.9 га, хүнсний ногоо 144.01 га-аас 1648.2 тн тус тус хураан аваад байна. 2011 онд 1 га талбайгаас 0.8 тн үр тариа, 10.4 тн төмс, 11.4 тн хүнсний ногоо хураан аваад байгааг урд оны га-гийн ургацтай харьцуулахад үр тариа урд оны түвшинд, төмс 0.9 тн-оор өндөр, хүнсний ногоо мөн 0.9 тн-оор өндөр байна.



Хадлан, тэжээл бэлтгэлтийн мэдээ 11 сарын байдлаар байгалийн хадлан 31.7 мянган тн, гар тэжээл 5.9 мянган тн бэлтгээд байгаа нь өмнөх оны мөн үеээс байгалын хадлан 385.4 тн буюу 1.5 хувиар, гар тэжээл бэлтгэлт 525 тн буюу 9.8 хувиар тус тус өндөр байна.

Хадлан, тэжээл бэлтгэл, сумаар




V. АЖ ҮЙЛДВЭР, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт 2011 оны эхний 11 сард (оны үнээр) 6031.9 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 1684.0 сая төгрөг буюу 38.7 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд нүүрс олборлолт, 0.2 хувь, цэвэр ус , талх, нарийн боов, хэрчсэн гурил, мод,модон эдлэл үйлдвэрлэл,хэвлэх, оёдол зэрэг боловсруулах аж үйлдвэрийн салбарын үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.2 хувиас 17.0 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Сүү, сүүн бүтээгдэхүүн, гутал зэрэг боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.2-24.8 хувиар буурсан байна.


Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад нүүрс олборлолт (24.4. %),хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл (45.2 %), оёдол (61.1 %),хэвлэх үйлдвэрлэл (23.5 %), Мод,модон эдлэлийн үйлдвэрлэл (12.4 %) , цахилгаан, дулаан, үйлдвэрлэл (13.2 %),ус ариутгал, усан хангамжийн үйлдвэрлэл (36.1 %), тус тус нэмэгдэж, хараа зүйн хэрэгсэл үйлдвэрлэлт 3.1 %), гутал үйлдвэрлэл (24.8 %),-иар буурчээ. Мэдээнд шинээр хамрагдсан цэг салбарын тоо нэмэгдсэн нь аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний өсөлтөд мөн нөлөөллөө.

Хүнсний зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл



Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн (оны үнээр 5654.5) сая төгрөгт хүрч, үүнээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 683.3 сая төгрөг, боловсруулах аж үйлдвэрийн салбарынх 3859.1 сая төгрөг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн салбарынх 1112.1 сая төгрөгт хүрч, нийт борлуулалтад уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 12.1 хувь болж 0.8 пунктээр буурч, боловсруулах аж үйлдвэрийн салбарынх 68.2 хувь болж 0.3 пунктээр өсч, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн салбарынх 19.7 хувь болж 0.5 пунктээр өслөө.

Борлуулсан бүтээгдэхүүн салбарын бүтцээр



Хөрөнгө оруулалт:


Хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр аймгийн хэмжээнд 2011 онд 21263.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэний 7.8 хувь нь орон нутгийн, 21.3 хувь нь гадаадын зээл, тусламж, хандиваар, 22.7 хувь нь иргэний өөрийн хөрөнгөөр, 48.0 хувь нь улсын төсвийн хөрөнгөөр хийгдээд байна.

VI. ХОЛБОО, ТЭЭВЭР, ХУДАЛДАА:

Тээвэр

Авто замын тээврээр 2011 оны эхний 11 сард давхардсан тоогоор 159.1 мянган зорчигч зорчиж, 18.3 мян. тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс зорчигчдын тоо 1.2 мян. хүн буюу 8.0 хувь, тээсэн ачаа 1.3 мян.тн буюу 7.6 хувиар өсчээ.

Зорчигч эргэлт, тээсэн ачаа



Тээсэн ачаа, зорчигчдын тоо өссөнөөр авто замын тээврийн салбарын орлого 2011 оны эхний 11 сард 1308.6 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 118.8 сая төгрөг буюу 10.0 хувиар өсчээ.

Холбоо

Холбооны тарифын орлого өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 10.2 хувиар өсч 238.7 сая төгрөг болсны дотор хүн амаас орсон орлого 0.3 хувиар өсч 47.8 сая төгрөгт хүрсэн байна. Телефон цэгийн тоо 1040 байгаа нь урьд оны мөн үеийхээс 403 -аар буурсан байна.

VII. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ:

Хэрэглээний үнийн индекс 11 сард өмнөх сартай харьцуулахад 2.7 хувиар, өмнөх оны жилийн эцсийнхээс 7.3 хувиар, өмнөх оны мөн үеийнхээс 2.7 хувиар өссөн байна.

Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 2.7 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлгийн үнэ дүнгээрээ 2.7 хувиар, гутал хувцас, бөс барааны бүлгийн үнэ 4.7 хувиар, орон сууц, ус цахилгаан, түлшний бүлгийн үнэ 9.9 хувиар өссөн нь нөлөөлжээ. Хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 2.7 хувиар өсөхөд мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ дүнгээрээ 5.1 хувиар, төрөл бүрийн өөх тосны дэд бүлгийн үнэ дүнгээрээ 3.5 хувиар, жимс жимсгэний дэд бүлгийн үнэ дүнгээрээ 1.1 хувиар, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ дүнгээрээ 9.2 хувиар өссөн нь нөлөөлжээ. Мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 5.1 хувиар өсөхөд хонины махны үнэ 6.1 хувиар, адууны махны үнэ 11.7 хувиар, сүү, сүүн бүтээгдэхүүн өндөгний дэд бүлгийн үнэ 9.2 хувиар өсөхөд сүүний үнэ 7.7 хувиар, айрагны үнэ 42.8 хувиар, өндөгний үнэ 12.0 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

2011 оны 11 сарын үнийн индекс өмнөх оны жилийн эцсийнхээс 7.3 хувиар өссөний дотор хүнсний бараа согтууруулах бус ундааны үнэ бүлгийн дүнгээрээ 2.9 хувиар, гутал хувцас, бөс барааны үнэ бүлгийн дүнгээрээ 10.2 хувиар, орон сууц ус цахилгаан түлшний үнэ бүлгийн дүнгээрээ 26.5 хувиар, гэр ахуйн барааны үнэ бүлгийн дүнгээрээ 8.4 хувиар, тээврийн үнэ бүлгийн дүнгээрээ 13.9 хувиар, боловсролын үйлчилгээний үнэ бүлгийн дүнгээрээ 12.1 хувиар, согтууруулах ундаа тамхины үнэ бүлгийн дүнгээрээ 0.4 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Тээврийн бүлгийн үнэ 13.9 хувиар өсөхөд А-80 бензиний үнэ 18.9 хувиар, АИ-92 үнэ 16.3 хувиар, дизель түлшний үнэ 22.3 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Орон сууц цахилгаан түлшний үнэ бүлгийн дүнгээрээ 26.5 хувиар өсөхөд орон сууцны цахилгааны үнэ 5.3 хувиар, гэр хорооллын цахилгааны үнэ 5.5 хувиар, 1 тонн нүүрсний үнэ 42.8 хувиар, 1 шуудай түлээний модны үнэ 25.0 хувиар, орон сууцны айл өрхийн халаалтын үнэ 2.2 дахин өссөн нь нөлөөлжээ.

VIII. НИЙТ БАРАА ГҮЙЛГЭЭ:

Аймгийн хэмжээнд эхний 11 сард 27974.5 сая төгрөгийн бараа гүйлгээ хийсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 4973.4 сая төгрөг буюу 21.6 хувиар өссөн байна. Аж ахуй нэгж иргэдийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 208 цэгээр буюу 19.8 хувиар өсчээ.

Бараа гүйлгээний орлого өмнөх оны мөн үеийнхээс 21.6 хувиар өсөхөд барааны дэлгүүрийнх 25.9 хувиар, хүнсний дэлгүүрийнх 13.2 хувиар, авто

сэлбэгийн дэлгүүрийнх 59.9 хувиар, барилгын материалынх 48.2 хувиар, ресторан барных 14.1 хувиар, цайны газрынх 12.8 хувиар, түцнийх 15.3 хувиар, авто засварын газрынх 98.1 хувиар, шатахуун борлуулалтынх 22.1 хувиар, эм борлуулалтынх 40.0 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Бараа гүйлгээний орлогын 3.2 хувийг барааны дэлгүүр, 16.9 хувийг хүнсний дэлгүүр, 2.5 хувийг авто сэлбэгийн дэлгүүр, 0.5 хувийг барилгын материалын дэлгүүр, 4.2 хувийг ресторан бар, 1.4 хувийг цайны газар, 0.2 хувийг түц, 3.2 хувийг контейнер, 2.1 хувийг авто засварын газар, 62.2 хувийг шатахуун борлуулалт, 3.5 хувийг эм борлуулалтын орлого эзэлж байна.

IX. ЭРҮҮЛ МЭНД:

Аймгийн хэмжээнд эхний 11 сард 2305 эх амаржиж, өмнөх оны мөн үеийнхээс 235 эхээр буюу 9.3 хувь, төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлтөөр) 2305 болж, 236 хүүхэд буюу 9.3 хувиар буурсан байна.

Нэг хүртэлх насандаа 59 хүүхэд эндэж өмнөх оны мөн үеийнхээс 14 хүүхдээр буюу 19.2 хувиар буурч, 1-5 хүртэлх насандаа 14 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеийнхээс 3 хүүхдээр буюу 27.3 хувиар өссөн байна.

Халдварт өвчнөөр эхний 11 сард 1203 хүн өвчилж өмнөх оны мөн үеийнхээс 341 хүнээр буюу 39.6 хувиар өссөн нь вируст гипатитаар өвчлөгчдийн тоо 406 хүн буюу 2.7 дахин их, салхин цэцгээр өвчлөгчдийн тоо 132 хүнээр буюу 2.7 дахин их, тэмбүүгээр өвчлөгчдийн тоо 22 хүнээр буюу 19.5 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Мөн цусан суулгаар өвчлөгчид өмнөх оны мөн үеийнхээс 69 хүн буюу 81.2 хувь, заг хүйтнээр өвчлөгчдийн тоо 63 хүн буюу 49.6 хувь, трихоминиазаар өвчлөгчдийн тоо 70 хүн буюу 64.8 хувь, сүрьеэгээр өвчлөгчдийн тоо 8 хүн буюу 10.3 хувиар буурчээ. Халдварт өвчин өмнөх оны мөн үеийнхээс Богд суманд 44 хүнээр буюу 2.1 дахин, Гучин –Ус суманд 48 хүн буюу 5.8 дахин, Нарийнтээл суманд 39 хүн буюу 3.8 дахин, Уянга суманд 49 хүн буюу 46.7 хувиар, Арвайхээр суманд 164 хүн буюу 40.9 хувиар тус тус өсчээ.

X. АЖИЛГҮЙЧҮҮД:


Аймгийн ХХҮХ-т бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 2351 болж, өмнөх оны мөн үеийнхээс 343 хүнээр буюу 12.7 хувиар буурчээ. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо өмнөх оны мөн үеийнхээс Баян-Өндөр суманд 10 хүнээр, Бүрд суманд 21 хүнээр, Өлзийт суманд 9 хүнээр, Сант суманд 11 хүнээр, Тарагт суманд 23 хүнээр, Хархорин суманд 191 хүнээр, Арвайхээр суманд 521 хүнээр тус тус буурсан нь ажилгүй нийт иргэдийн тооны бууралтад голлон нөлөөлжээ. Эхний 11 сард ажилгүй 311 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй байсан 343 иргэн ажилд зуучлагдан орж, 522 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна. ХХҮХ-т эхний 11 сард шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд өмнөх оны мөн үеийнхээс 199 хүнээр буюу 2.8 дахин өсчээ. Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэдийн дотроос бусад шалтгаанаар ажилгүй болсон иргэдийн тоо 12 дахин өмнөх оны мөн үеийнхээс өсч, орон тооны цомхотголоор ажилгүй болсон иргэдийн тоо 96.7 хувь, өөр газраас шилжиж ирсэн 60 хувь, сургууль төгссөн 12.5 хувь, мэргэжлийн ажил олдоогүй шалтгаанаар ажилгүй болсон иргэдийн тоо 50.0 хувиар тус тус буурчээ. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 1274 буюу 54.2 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 3.7 пунктээр өссөн байна.

Аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 1262 буюу 53.7 хувь нь 16-34 насны залуучууд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 14.4 хувь нь дээд, 4.8 хувь нь тусгай дунд, 5.1 хувь нь мэргэжлийн анхан шатны, 31.4 хувь нь бүрэн дунд, 37.3 хувь нь бүрэн бус дунд, 6.3 хувь нь бага, 0.7 хувь нь боловсролгүй хүмүүс байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад дээд боловсролтой иргэдийн тоо 0.9 пунктээр, бага 1.0 пунктээр, өсч, бүрэн дунд боловсролтой иргэдийн тоо 0.8 пунктээр, бүрэн бус дунд 0.5 пунктээр буурсан байна. Ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо эхний 11 сард 343 болж, өмнөх оны мөн үеийнхээс 7.6 дахин өссөн байна.

Ажилд зуучлагдан орсон нийт иргэдийн 10.2 хувь нь улсын үйлдвэрийн газарт, 2.6 хувь нь төрийн төсөвт байгууллагад, 26.5 хувь нь нөхөрлөл компанид, 60.6 хувь нь бусад байгууллагад оржээ.

Шинээр бүртгүүлсэн ажилгүйчүүд болон ажилд зуучлагдан орсон хүний тоо



Оны эхний 11 сард 1614 ажлын байр шинээр бий болж, үүний 8.8 хувь нь барилгын салбарт, 42.9 хувь нь ХАА-н салбарт, 11.0 хувь нь боловсруулах үйлдвэрт, 9.4 хувь нь нийгэм бие хүнд үзүүлэх үйлчилгээнд, 6.7 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 4.0 хувь нь зочид буудал зоогийн газарт, 1.3 хувь нь боловсролын салбарт, 15.9 хувь нь бусад салбаруудад бий болсон байна. Шинээр бий болсон ажлын байрны 39.6 хувь эмэгтэй ажиллагсадтай байгаагийн дотор ХАА-н салбарт 36.4 хувь, уул уурхай, олборлох үйлдвэрт 8.1 хувь нь, боловсруулах үйлдвэрт 16.1 хувь нь, барилгын салбарт 5.5 хувь нь, бөөний болон жижиглэн худалдааны салбарт 10.5 хувь нь, зочид буудал зоогийн газарт 6.2 хувь нь, төрийн удирдлага батлан хамгаалах, албан журмын даатгалд 41.2 хувь нь, боловсролын салбарт 2.2 хувь нь, эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарт 0.8 хувь нь, бусад салбарт 12.3 хувь нь ажиллаж байна.

ХИ.ГЭМТ ХЭРЭГ:

Аймгийн хэмжээнд эхний 11 сарын байдлаар 436 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 43 гэмт хэргээр буюу 10.9 хувиар өссөн байна. Үүнд өмнөх оны мөн үеийнхээс бусдын амийг хорлох гэмт хэрэг 25.0 хувиар, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 54.2 хувиар, иргэний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 17.8 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 64.7 хувь нь сумдад, 35.3 хувь нь аймгийн төвд бүртгэгджээ.

Хүүхэд оролцсон гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс 18 гэмт хэргээр буюу 2.8 дахин өсчээ. Хулгайлах гэмт хэргийн 54.4 хувийг иргэдийн орон

байрны хулгай, 38.2 хувийг малын хулгай, 7.4 хувийг авто тээврийн хэрэгслийн хулгай тус тус эзэлж байна. Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс Нарийнтээл суманд 14.3 хувиар, Тарагт суманд 40.0 хувиар, Хархорин суманд 25.0 хувиар, Богд суманд 71.4 хувиар, Бүрд суманд 87.5 хувиар, ЗБУлаан суманд 6.6 хувиар, Арвайхээр суманд 16.7 хувиар, Бат-Өлзий суманд 3.4 хувиар, Баянгол суманд 3.5 дахин нэмэгдэж, Гучин-Ус суманд 60.0 хувиар, ББУлаан суманд 28.6 хувиар, Төгрөг суманд 45.5 хувиар, Уянга суманд 7.7 хувиар, Хайрхандулаан суманд 16.7 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 41.5 хувийг хөнгөн хэрэг, 49.3 хувийг хүндэвтэр хэрэг, 5.5 хувийг хүнд хэрэг, 3.7 хувийг онц хүнд хэрэг тус тус эзэлж өмнөх оны мөн үеийнхээс хөнгөн хэрэг 2.3 пунктээр, хүндэвтэр хэрэг 10.5 пунктээр, онц хүнд хэрэг 1.6 пунктээр өсч, хүнд хэрэг 4.2 пунктээр буурсан байна. Гэмт хэрэгт холбогдсон 415 сэжигтэн, яллагдагчийн 263 буюу 63.4 хувь нь 18-35 хүртэл насных, 107 буюу 25.8 хувь нь 35-аас дээш насныхан байна. Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдад ажилчин, малчины эзлэх хувь 33.7 хувь, төрийн албан хаагч 6.3 хувь, Оюутан, сурагч 10.4 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэгч 6.5 хувь, ажилгүй иргэд 38.3 хувь байна.

Хамтран үйлдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс 4.0 хувиар өсч, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг өмнөх оныхоос 20.2 хувиар буурсан байна. Гэмт хэргийн улмаас 166 хүн гэмтэж, 105 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтэж бэртсэн хүний тоо 22 буюу 15.3 хувиар, нас барсан хүний тоо 30 буюу 40.0 хувиар тус тус өссөн байна.



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД
MAIN INDICATORS

12/6/2011

Үзүүлэлтүүд	/Indicators/	Хэмжих нэгж /Unit/	2009	2010	2011	2011/ 2010%
Төсвийн орлого	/budget revenue/	сая.төг mln.tog	3357.9	5897.5	7180.3	121.8
Төсвийн зарлага	/Budget expenditure/	сая.төг mln.tog	24940.3	28060.6	33544.8	119.5
Зээлийн өрийн үлдэгдэл	/Remainder of loan debts/	сая.төг mln.tog	31000.3	33241.4	62465.9	187.9
Үүнээс: хугацаа хэтэрсэн	/whom: outstanding debts/	сая.төг mln.tog	557.3	271.2	209.2	77.1
Хадгаламж	/Deposits/	сая.төг mln.tog	16899.5	19756.2	29988.1	151.8
Төллөсөн хээлтэгч	/Breeding stock/	мян.тол /thous.heads/	1244.3	541.1	818.8	151.3
Бойжсон төл	/rearing of young animals/	мян.тол /thous.heads/	1148.2	292.1	794.2	2.7 дах
Том малын зүй бус хорогдол	/Losses of adult animals/	мян.тол /thous.heads/	103.4	1643.6	20.8	1.3
Ургац хураалт /total crops / :						
Үр тариа /Cereals/		тн /tn/	702	1088.5	2057.0	189.0
Төмс/Potatoes/		тн /tn/	2392	2655	3068.9	115.6
Хүнсний ногоо/Vegetable/		тн /tn/	1446.4	1458.5	1648.2	113.0
Аж үйлдвэрийн НБ	/Gross industrial output/	сая.төг mln.mog	3036.9	4347.9	6031.9	138.7
Борлуулсан бүтээгдэхүүн	/Sold production/	сая.төг mln.tog	2754.1	4258.7	5654.5	132.8
Тээсэн ачаа	/Carried freight/	мян.тн /thous.tn	15.8	17	18.3	107.6
Зорчигч зргэлт	/Passenger turnover/	мян.хүн.км /thouspass.km/	34227	44245	45683.4	103.3
Холбооны орлого	/Revenue of communication/	сая.төг mln.tog	266.6	216.7	238.7	110.2
Телефон цэг	/Number of telephones/	тоо/number/	1614	1443	1040	72.1
Ажилгүйчүүд /Unemployment/		хүн/people/	2902	2694	2351	87.3
Халдварт өвчнөөр өвчлөгчид disease cases/	/number of infectious	хүн/people/	930	862	1203	139.6
1 хүртэл насандаа эндсэн хүүхэд years/	/infant deaths at age of 1	хүн/people/	64	73	59	80.8
Бүртгэгдсэн хэрэг/Offences/		тоо/number/	329	393	436	110.9
Хэрэгт холбогдогсад /Offenders/		хүн/people/	354	387	415	107.2

1.2 ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА сумаар, оны үнээр, мян.төг
 BUDGET REVENUE, EXPENDITURE ,by soum , at current prices , thous.tog

Сум	Орлого Revenue			Зарлага Expenditure		
	2011			2011		
	төл	гүйц	%	төл	гүйц	%
Баян-Өндөр	48880	53658.5	109.8	820,147.5	785,500.5	95.8
Бүрд	55006.6	46621.2	84.8	688,275.0	698,116.5	101.4
Бат-Өлзий	116588	159641	136.9	1,273,396.5	1,204,625.6	94.6
ББ-Улаан	36299	42996.3	118.5	771,892.0	716,673.5	92.8
Баянгол	35567.7	50326	141.5	843,465.9	820,106.9	97.2
Гучин-Ус	40976.4	46488.1	113.5	693,840.9	674,770.1	97.3
Есөнзүйл	41672	48101.9	115.4	845,770.7	791,357.9	93.6
Өлзийт	35847	45139.7	125.9	650,486.1	644,256.0	99.0
ЗБ-Улаан	48130	50895.5	105.7	721,280.0	719,845.1	99.8
Богд	68859.4	59778.5	86.8	1,187,546.7	1,102,354.8	92.8
Нарийнтээл	67382.9	85737.9	127.2	955,310.3	921,267.3	96.4
Сант	47183.9	51896	110.0	881,047.5	832,596.9	94.5
Тарагт	37952.2	44657.3	117.7	750,372.5	695,763.8	92.7
Төгрөг	41322.9	46919.5	113.5	789,391.3	774,015.7	98.1
Уянга	602870.2	426068.5	70.7	1,670,226.0	1,591,418.9	95.3
Хайрхандулаан	35073.1	44272.3	126.2	781,328.9	705,857.4	90.3
Хужирт	113294.8	156235.6	137.9	1,372,477.4	1,303,747.5	95.0
Хархорин	343745.0	450334.3	131.0	2,590,740.8	2,466,177.1	95.2
Арвайхээр	1016880.3	1463200	143.9	4,038,744.9	3,913,928.9	96.9
Сум дүн Soum total	2833531.4	3372968.2	119.0	22325740.9	21362380.4	95.7
Аймгийн шууд	4462769.5	3807327	85.3	13,301,155.7	12,182,487.6	91.6
Аймаг дүн Aimag total	7296300.9	7180295.3	98.4	35626896.6	33544868.0	94.2

04-Дес-11
 СЭЗТСХ-ийн мэдээг үндэслэв.

**1.ТӨСӨВ
BUDJET**

I.1 АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО,оны үнээр,мян.төг
STATE BUDGET REVENUE OF AIMAG, at current prices, thous.tog

Төсвийн орлого	гүйц	2011		Budget revenue
	2010	төл	гүйц	
Татварын орлого	3103543.5	3752544.7	3409215.5	Tax revenue
-Хүн амын орлого	1714390.5	2678858	1974604.5	-Individuals
- Өмчийн татвар	66084.4	65463.6	84893	-Property tax
- Бусад татвар	620729.6	366490.4	1029479.3	-Other tax
Татварын бус орлого	244509.2	113960.8	256396	Non-tax revenue
Хөрөнгийн орлого	49899.2	45400.0	103671.8	Capital revenue
Санхүүгийн дэмжлэг	2500000	3384395.4	3411012	
Дүн	5897951.9	7296300.9	7180295.3	Total

I.1 АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА,оны үнээр,мян.төг
STATE BUDGET EXPENDITURE OF AIMAG, at current prices, thous.tog

Төсвийн зарлага	гүйц	2011		Budget expenditure
	2010	төл	гүйц	
-Цалин хөлс	15929782	20305267	19488755.5	-Wages&salaries
-Нийгмийн даатгалын шимтгэл	1621907.8	2008536.8	1835058.2	-Social security contribution
-Эрүүл мэндийн даатгал	1601.8	125586.5	181184.4	-Health insurance
-Бараа үйлчилгээний бусад зардал	8127509.4	11624383	10723403.8	-Goods and services expenses
Татаас ба шилжүүлэг	1266772.2	1531215.1	1304165.9	-Subsidie & transfers
-Хөрөнгө оруулалт	1113122.3	31909.2	12300	-Investment
НИЙТ ЗАРДАЛ	28060696	35626896.6	33544867.8	TOTAL EXPENDITURE

СЭЗТСХ-ийн мэдээг үндэслэв.

ӨГЛӨГИЙН МЭДЭЭ

12/6/2011

	Нийт өглөг	Үүнээс:									
		Ажиллагсад олгох цалин	Нийгмийн даатгалын шимтгэл	Эрүүл мэндийн даатгалын хэмжээ	Гэрэл цахилгаан	Түлш халаалт	Тээвэр	Шуудан холбоо	Хоол	Эм	Бусад
Эхний үлдэгдэл	744564.8	37748.2	38000.5	813.3	29566.2	122859.3	144077.5	3214.8	60186.1	178769.0	129329.9
Тухайн сард төлөгдсөн өглөг	342453.2	31478.3	36921.1	813.3	5445.6	73987.0	73352.3	3088.2	24039.8	18453.9	74873.7
Тухайн сард шинээр үүсэн өглөг	237408.1	29021.4	11283.4	0.0	400.2	13866.7	14253.9	973.9	30882.0	91137.0	45589.6
Эцсийн үлдэгдэл	638519.7	35291.3	12362.8	0.0	24520.8	62739.0	84979.1	100.5	67028.3	251452.1	100045.8
өглөг үүсэн хугацаа	31-60 өдөр	34491.3	12274.8	0.0	24348.8	18655.5	63488.7	746.9	52266.0	103872.1	81222.0
	61-120 өдөр	238166.9	800.0	88.0	0.0	200.0	43075.3	19365.4	54.5	11762.3	145230.0
	121 өдрөөс дээш	9986.7					1008.2	2125	299.1	3000	2350

БАНКНЫ КАССЫН ОРЛОГО, ЗАРЛАГА /мян.төг/

12/6/2011

д/д	Үзүүлэлтүүд	Indicators	ХААН банк Khan bank	Хадгаламж банк Saving bank	ХАС банк Khas bank	Төрийн банк bank
1	Монгол банкнаас арилжааны банкуудад хийсэн зузаатгал		13410000.0	3954000.0	3602060.0	430000.0
2	Банкны кассын орлого		40483612.0	20638704.5	29151268.9	6835451.6
3	Монгол банкинд гүйлгээнээс орсон татаас		17903930.0	6500.0	3958940.0	71500.0
4	Банкны кассын зарлага		35800603.0	20690471.1	29446273	6051831.8
5	Зээлийн өрийн бүх үлдэгдэл		36752497.0	9375104.8	15268780	1069542.4
6	Үүнээс: Хугацаа хэтэрсэн зээл		84901.0	6334.3	111118.2	6849.0
7	Байгууллага, иргэдийн хувийн хадгаламж		19049988.0	5629410.1	3973765.1	1334980.5
8	Дүн		163485531.0	60300524.8	85512204.6	15800155.3

Нийгмийн даатгалын сангуудын зарцуулалтын мэдээ

мян.төг

Үзүүлэлтүүд						Өссөн дүнгээр	
1	Орлого	Нийгмийн даатгалын сангуудын нийт орлого				Төлөвлөгөө	17281753.6
						Гүйцэтгэл	18478120.1
						Хувь	106.9
	Үүнээс	Төсвийн дотац			Төлөвлөгөө	11294500.0	
					Гүйцэтгэл	11294500.0	
					Хувь	100.0	
		НДШ-ийн орлого			Төлөвлөгөө	5987253.6	
					Гүйцэтгэл	7183620.1	
					Хувь	120.0	
	Үүнээс	Нийгмийн даатгалын сайн дурын орлого			Төлөвлөгөө	293711.8	
					Гүйцэтгэл	497607.6	
					Хувь	169.4	
